



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 16

Мандалговь

Хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 3 дахь заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Сайхан-Овоо сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 17,645,000 /арван долоон сая зургаан зуун дөчин таван мянга/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй 52-52 ДУА улсын дугаартай УАЗ-315122 маркын тээврийн хэрэгслийг Сайхан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуульд балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр: Хөрөнгийг зохих хууль журмын дагуу байгууллагын данс бүртгэлээс хасахыг Сайхан-Овоо сумын ЗДТГ-ын дарга С.Болоржаргал, бүртгэж авахыг Сайхан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал О.Түмэнбаатар нарт тус тус даалгасугай.

Гурав: Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга (Ц.Мөнгөнцоож)-д үүрэг болгосугай

ДАРГА



С.СҮХБААТАР